



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 22 өдөр

Дугаар 1265

Булган сум

Татвар төлөгчдийн өдрүүдийг
тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, Татварын ерөнхий хуулийн 34.11.1, Сангийн сайдын 61 дугаар тушаалаар батлагдсан "Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Татвар төлөгчдийн өдрүүд 2022" арга хэмжээг Булган аймагт 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрөөс 14-ний өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулахыг Татварын хэлтэс /Д.Лхагвасүрэн/-т даалгасугай.
2. "Татвар төлөгчдийн өдрүүд 2022" арга хэмжээний зардлыг хавсралтаар баталж, уг арга хэмжээнд зарцуулагдах 6,000,000 (зургаан сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газар /Д.Алтаншагай/-т зөвшөөрсүгэй.
3. Татвар төлөгчдийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлсэн тухай тайланг 6 дугаар сарын 01-ний дотор аймгийн Засаг даргын тамгын газарт тайлагнахыг Татварын хэлтэс /Д.Лхагвасүрэн/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6320220321